



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 24 № 3/521
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.НАРАНЧИМЭГ



**“АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ
ИХ СУРГУУЛЬ”-ИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Захиалагч:

УАГ-ын САГ-ын дарга
Ц.Наранчимэг
Утас: 263533

Аудитын менежер
Я.Самбууням
Утас:260512

Аудитор
Н.Нямдаваа
Утас: 261885

Монгол Улсын Үндэсний
Аудитын Газар
Засгийн газрын IV байр, Бага
тойруу-6, Улаанбаатар-46, Монгол
улс
Вэб хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

“Хүлэгтхүннү Аудит” ХХК

Гүйцэтгэх захирал
Е.Оюундэлгэр
Утас:70140505
Гар утас: 88084464
Цахим хаяг:
oyundelger@hulegthunnu.mn

Аудитор
Ё.Наранбилэг
Утас: 88003980
Цахим хаяг:
naranbileg@hulegthunnu.mn
Хаяг:Чингэлтэй дүүрэг, 6-р хороо,
Логос төв, 9 давхар, 903 тоот

Аудитынтайлан

Хавсралт 1.Агуулга

Хавсралт 2. Аудитын гэрчилгээ

Хавсралт 3.Менежментийн захидал

Хавсралт 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар
11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Санал дүгнэлтийн үндэслэл
18. Зөвлөмж
19. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1 заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 зүйлд заасан Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд /САГ/2017/54/СТА-ТШЗ/ Үндэсний аудитын газрын захиалгаар “Хүлэгтхүннү Аудит” ХХК аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланг Монгол Улсын“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, Улсын Секторын Нягтлан Бодох БүртгэлийнОлонУлсынСтандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтланбодохбүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

БСШУСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль болон Дорноговь аймаг дахь салбар сургуулийн 2016 оны эхний 8 сарын санхүүгийн тайлан,төсвийн зарцуулалтанд түүвэрчилсэн байдлаар аудит хийж гүйцэтгэн 14 зөвлөмж хүргүүлсэн байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны тусдаа болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 13-наас 2017 оны 3 дугаар сарын 16-ны хооронд хийхээр төлөвлөн “Хүлэгтхүннү Аудит” ХХК-ийн аудитор Ё.Наранбилэг,Ц.Магнайдүүрэн аудиторов туслах Б.Нандинчулуун, О.Анужин нар гүйцэтгэж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 7-нд “Хүлэгтхүннү Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Хүлэгтхүннү Аудит” ХХК аудитыг 2017 оны 2дугаар сарын 13-наас 2017 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны3 дугаар сарын 24-нд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд хүргүүлж байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Боловсролын тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа

явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж 2016 оны 1 сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус сургууль нь Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Номхон Далайн Баруун Эргийн Бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг болох зорилготой ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд Боловсрол шинжлэх ухааны яам ерөнхий хяналт тавьж ажилладаг.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад дэлгэрэнгүй тусгасан болно.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар, Шилэн дансны тухай хууль, Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын гарын авлагын арга зүйг ашиглав.

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 19 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт туссан зүйлс нь УСНББОУС-тай нийцсэн байгаа боловч зарим тайлагнал хэмжилттэй холбоотой асуудлууд дутуу тусгагдсан байна. Мөн нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад хэрэгцээтэй бодлогын баримт бичгийн хэрэглээний талын асуудлууд (аргачлал, тооцоолол, бүртгэлийн горим, хуулийн зарим хэрэглээний асуудал г.м) огт тусгагдаагүй байна. Санхүүгийн тайлангаа "Ординат" ХХК-ийн "VINNICA" санхүүгийн програм хангамжийг ашиглан бүртгэл хөтлөдөг бөгөөд уг санхүүгийн программын ашиглалт болоод үйлчилгээ хангалтгүй байсан төдийгүй сургуулийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

АШУУИС-ИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин:

Материаллаг байдлыг төлөвлөлтийн үе шатанд нийт хөрөнгийг суурь үзүүлэлт болгон 0.2 хувиар буюу 73.7 сая төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцож үзээд төлөвлөлтийн үеийн материаллагийн түвшинг хэвээр нь авах зүйтэй гэж үзлээ.

Дотоод хяналт:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь 2007 оноос байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох боловсролын үйлчилгээ, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хяналт тавих зорилгоор захиргаа хяналт, шинжилгээ үнэлгээний албыг, 2013 оноос төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулан ажилласан байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын эрсдэл бага байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдах зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 012 тогтоолоор 2016 оны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөг хэлэлцэж баталсан байна.

2016 оны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөгөөр нийт 30,104.4 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 34,205.8 сая төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 13.6 хувиар буюу 4,101.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2016 оны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөгөөр нийт 33,604.4 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 27,759.2 сая төгрөгийн зардалтайгаар ажиллаж, төлөвлөсөн нийт зардлыг 17.4 хувиар буюу 5,845.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна. Харин зардлын зүйл ангиар нь зардлын хэтрэлтийг авч үзвэл, Шуудан, холбооны зардал 43.0 сая төгрөгөөр буюу 64 хувиар, Төлбөр, хураамж, жижиг татварын зардал 21.0 сая төгрөгөөр буюу 16 хувиар төлөвлөсөн хэмжээнээс хэтэрсэн бол, Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр 43.4 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гарсан байна.

Шуудан, холбооны зардал төлөвлөсөн хэмжээнээс 43.0 сая төгрөгөөр буюу 64 хувиар өссөн нь сургуулийн болон оюутнуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн интернетийн үзүүлэлтийг (хурд, хамрах хүрээ г.м)-ийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор, Төлбөр, хураамж, жижиг татварын зардал төлөвлөсөн хэмжээнээсээ 21.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь 2016 оноос АШУИС-ийн Лицей сургуулиас 21 дүгээр сургуулийн байр

ашигласны төлбөрийг нийт дүнгээр нь тайлагнасантай(өмнө нь цэвэрлэж тайлагнадаг байсан) холбоотой бол, Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр төлөвлөгдөлгүйгээр 43.4 сая төгрөг гарсан байгаа нь 2016 оноос эхлэн БСШУСЯ-наас баруун таван аймгийн оюутны унааны зардлын төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь тайлагналыг өөрчилсөнтэй холбоотой (өмнө нь сургуулиудын хувьд сургалтын төрийн сангаас авсан дүн, оюутнуудад өгсөн дүнг төсвийн гүйцэтгэлийн тайланд цэвэрлэн тайлагнадаг байсан)байна.

Шилэн дансны мэдээлэл:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн хүрээнд шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсаархүргэж байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын9эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын шалгалтыг гүйцэтгэхэд Ахмадын сан байгуулаагүй, хүүгийн орлогыг мөнгөн сууриар тооцож дутуу бүртгэсэн, бараа материалыг үл хүлээн зөвшөөрөлтийг бүртгээгүй, газар эзэмших эрхийг үнэлж, бүртгээгүй, үндсэн үйл ажиллагааны орлого (сургалтын төлбөрийн орлого)-ыг оновчтой бус сууриар тооцоолсон, үндсэн хөрөнгө барьж байгуулахад зарцуулсан мөнгөн хөрөнгийг буруу үзүүлтэд хамааруулан тайлагнасан нь иж бүрэн, хэмжилт, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

2016 оны эцэст 3,074.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа ба энэхүү авлагын дийлэнх хувийг хадгаламжийн хүүгийн авлага (751.8 сая төгрөг), БСШУСЯ-наас авах тогтмол зардлын санхүүжилтийн авлага (988.9 сая төгрөг), боловсролын зээлийн сангаас авах авлага (421.1 сая төгрөг) бүрдүүлж байна.Аудиторын зүгээсхүүгийн авлага, тогтмол зардлын санхүүжилтийн авлага, боловсролын зээлийн сангийн авлагын үлдэгдэлд хөндлөнгийн тулган баталгаажуулалт хийж үлдэгдлийг баталгаажуулсан.

2016 оны эцэст 4,443.5 сая төгрөгийн дуусаагүй барилгын үлдэгдэлтэй байна. Энэхүү үлдэгдэл нь Сургалтын нэгдсэн цогцолборын дуусаагүй барилгын 3,084.3 сая төгрөгийн, Нүүр ам судлалын сургуулийн өргөтгөлийн дуусаагүй барилга 1,359.2 сая төгрөгийн үлдэгдлээс бүрдэж байна. Эдгээр хөрөнгө оруулалтын ажлыг АШУУИС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, эхлүүлсэн байна.

2016 оны санхүүгийн тайланд материаллаг хэмжээний алдаа илэрхийлэгдээгүй байна. Үүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 87,369.11 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, орлого, зардал,

АШУУИС-ИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

санхүүгийн тайлан зэрэгтажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсэн горим, сорилыг бэлтгэн шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорилд тус байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 100%, бараа материалын үлдэгдлийн 100%, үндсэн хөрөнгийн 50%, авлага өглөгийн үлдэгдлийн 100%, орлогын 100%, зарлагын 30%, биет бус хөрөнгийн 100%-ийг тус тус хамруулав.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийгшийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Оюутны сургалтын төлбөрийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ одоо явагдаж буй сургалтын кредит системтэй уялдаа холбоогүй буюу өмнөх сургалтын системийн үед ашиглагдаж байсан аргаар (орлого тооцохдоо нийт хичээллэх сарыг суурь болгох) орлогоо тооцоолж бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 9(19)-д “Үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадах тохиолдолд тайлангийн өдрийн ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг харгалзан уг ажил гүйлгээтэй холбогдох орлогыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй”, 9(20)-д “Ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг баримтлан орлогыг хүлээн зөвшөөрөхийг гүйцэтгэлийн хувийн жингийн арга гэж нэрлэдэг. Энэ аргын дагуу үйлчилгээг үзүүлсэн тухайн тайлант үеүдэд орлогыг хүлээн зөвшөөрдөг”, 19(21)-д “Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадвахи уг байгууллагад орох магадлалтай байгаа тохиолдолд л орлогыг хүлээн зөвшөөрнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Сургалтын орлогыг 300.6 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлогыг 5.9 сая төгрөгөөр, дансны авлагыг 306.4 сая төгрөгөөртус тус бууруулах, УСНББОУС-9 “Орлого”-д заасны дагуу оновчтой суурь (кредит цаг) ашиглан тооцож бүртгэх талаар зөвлөмж өгсөн.

2. Нийт 617.6 сая төгрөгийн бараа материалыг ашиглалтанд тавьж олгосон боловч үл хүлээн зөвшөөрөлтийг бүртгээгүй байна (2016 оноос өмнөх хугацаанд 420.1 сая төгрөг, 2016 онд 197.5 сая төгрөг). Сургуулийн хувьд зарим төрлийн бараа материал (эмнэлгийн жижиг багаж, хэрэгсэл г.м)-ын хувьд ашиглалтанд тавьж олгосон үед нь бус тэдгээрийг хэрэглэж дууссан, ашиглах боломжгүй болсон үед нь данснаас хасаж бүртгэдэг байна. Ингэж бүртгэдгийн гол зорилго нь, тэдгээр хөрөнгийн ашиглалт болоод бүрэн бүтэн байдалд хяналт тавих зорилготой байна. Мөн ЭЗБАС-ийн хувьд, нийт 11 нэр төрлийн барааны тоо хэмжээг зарлагдахдаа 2 дахин нэмэгдүүлэн зарлагадсан, 1 нэр төрлийн барааны өртгийг зөрүүтэй зарлагадснаас тайлагналын өдрөөрх бараа материалын үлдэгдлийг 0.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн бол, НАСС-ын хувьд 1 нэр төрлийн барааны өртөг болон тоо хэмжээг зөрүүтэй зарлагадснаас тайлагналын өдрөөрх бараа материалын үлдэгдлийг дутуу(0.05 төгрөгөөр) илэрхийлсэн байна.

Энэ нь УСНББОУС 12(44)-д “Бараа материалыг борлуулах, солилцох буюу хуваарилах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв холбогдох орлого байхгүй бол барааг хуваарилах буюу холбогдох үйлчилгээг

үзүүлэхэд гарсан зардал гэж хүлээн зөвшөөрнө”, УСНББОУС 1(27)-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Бараа материалын дүнг 1,046.3 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнг 779.1 сая төгрөгөөр, тайлант үеийн зардлыг 267.2 сая төгрөгөөр тус тус бууруулах, УСНББОУС-12 “Бараа материал”-ын дагуу бүртгэх зөвлөмж өгсөн.

3. ХААН банкин дахь 1 жилийн хугацаатай хадгаламжийн хүүгийн орлогыг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

2015.02.05-2016.02.04-ны хоорондох хугацааны хүүгийн орлого нь 172.0 сая төгрөг, 2016.02.05-2017.02.04-ны хоорондох хугацааны хүүгийн орлого нь 432.3 сая төгрөг, сургууль зөвхөн 2016 оны 2 сарын 5-нд мөнгөөр хүлээн авсан 172.0 сая төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 5 дугаар зүйлд “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүүгийн орлогыг 231.5 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнг 155.0 сая төгрөгөөр, бусад авлагыг 386.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж бүртгэх, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Сургуулийн ахмад настнуудтай холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотойгоор сан үүсгэдэггүй бөгөөд 2016 онд ахмадуудыг хүлээн авахад 8.9 сая төгрөгийг зарцуулж, түүнийгээ тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Сургууль нь бидний авч үзсэнээр 2015, 2016 онд үйл ажиллагааны зардлын хэмнэлттэй ажилласан байна.

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн 8.5-д “Энэ хуулийн 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан төсөвт байгууллага үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, аж ахуйн нэгж, байгууллага үлдэгдэл ашгаас цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулна” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хууль, Засгийн газраас баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

2. Ашиглаж байгаа боловч дансны үнэ тэглэсэн 4,784 ширхэг, 1,823.1 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгүүдийг дахин үнэлүүлээгүй байна. Сургууль нь дээрх 4,784 ширхэг хөрөнгийг харьяалж буй ангийн хувьд дахин үнэлгээний загварыг ашигладаг.

УСНББОУС 17(49)-т “Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийг дагаж мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

3. Нийт 11 байршилд газар ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрээс 10 байршил (252,746 м2)-д газар эзэмших эрхийн гэрчилгээ аван үйл ажиллагаа

явуулж байгаа бол 1 байршил (оюутны 1-р байр)-д газар эзэмших болон ашиглах эрхийг авалгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.

10 байршил дахь газар эзэмших эрхийг 2015 оноос өмнөх онуудад буцалтгүй тусламжаар хүлээн авсан боловч тэдгээрийг үнэлж, хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Аудитын явцад АОУС-ын дагуу сургуулийн удирдлагад газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгах боломжоор хангаж өгөх талаар саналаа (албан бичгээр) илэрхийлж, сургуулийн удирдлага хүлээн авч үнэлгээг гаргаж өгсөн болно. Үнэлгээчин, эзэмших эрхийн гэрчилгээ бүхий 10 байршил дахь газар эзэмших эрхийг 118,930.1 сая төгрөгөөр үнэлсэн байна.

Газар эзэмших эрхийг үнэлж, хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь УСНББОУС 31(28)-д “Биет бус хөрөнгийг дараах тохиолдолд л хүлээн зөвшөөрч бүртгэнэ. а) Хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадвахийг байгууллага хүртэх магадлалтай бол, б) Хөрөнгийн өртгийг эсвэл бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжих боломжтой бол”, 31(42)-д “Зарим тохиолдолд, биет бус хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр дамжуулан олж авч болно...”, 31(43)-д “Эдгээр нөхцөлд биет бус хөрөнгийн өртөг нь худалдаж авсан өдрийн байдлаарх бодит үнэ цэнэ юм...” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: УСНББОУС-31 “Биет бус хөрөнгө”-ийг мөрдөжажиллахыг зөвлөсөн.

4. 2016 онд буцалтгүй тусламжаар нийт 309 ширхэг, 734.7 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө хүлээн авсныг “Засгийн газрын оруулсан капитал”-ыг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2013 оны 12 сарын 02-ны өдрийн 269 тоот тушаалын 1-т “хөрөнгийг бодит үнэ цэнээр нь орлогоор бүртгэнэ, дт: үндсэн хөрөнгө, кт: орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 269 тоот тушаалыг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

5. Төрийн банкны зүгээс сургуулийн хадгаламжийн дансанд жилийн эцэст бодож олгосон 21.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг 2016.12.31-ны өдөр ХААН банкин дахь сургуулийн данс руу шилжүүлж, уг мөнгө нь Монгол банкинд хянагдан, тайлагналын үе дамжин 2017.01.02-ны өдөр ХААН банкин дахь харилцах дансанд орсныг ХААН банкнаас авах хүүгийн авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 3(12)-д “Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлыг бүртгэхэд тусгайлан хэрэглэх УСНББОУС байхгүй тохиолдолд удирдлага дараах мэдээлэлд хүргэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулах болон хэрэглэхдээ өөрийн мэргэжлийн шийдлийг ашиглах хэрэгтэй”, 3(15)-д “Уг стандартын 12-р зүйлд заасан мэргэжлийн шийдлийг гаргахдаа удирдлага ... улсын болон хувийн секторын хүлээн зөвшөөрөгдсөн практик туршлагыг мөн адил харгалзан үзэх хэрэгтэй, практикт “Замд яваа мөнгө”-өөр бүртгэж байгаатай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: УСНББОУС-3 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт ба алдаа”-г мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

6. 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9 зөвлөмж өгсөнөөс 8 зөвлөмжийг биелүүлж ажилласан бол, доорх 1 зөвлөмжийг биелүүлэлж ажиллаагүй байна. Үүнд, “Ажилчдад олгосон шагнал урамшууллаас холбогдох хуулийн дагуу НДШ-ийг суутган олгож байх” зөвлөмжийг өгсөн боловч 2016 онд ажилчдад олгосон шагналаас нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцоогүй байна.

Энэ нь “Аудитын тухай” хуулийн 14.2.5-д “шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлантай холбоотой хүлээн зөвшөөрсөн алдаа, зөрчлийг шуурхай залруулах”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 15.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: “Аудитын тухай” хууль, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

7. Говь-Алтай аймгийн салбар сургууль, гадаад валютаарх ажил гүйлгээний бүртгэлд албан ханш хэрэглээгүйгээс гадаад валютын ханшийн зөрүүгийн гарзыг 1.3 сая төгрөгөөр дутуу, барилгын капиталжуулалтыг 1.3 сая төгрөгөөр тус тус илүү бүртгэсэн, мөн уг барилгын капиталжуулалтыг 1.3 сая төгрөгөөр илүү бүртгэсэн болон элэгдүүлэх хугацааг илүү тооцоолсноос элэгдлийн зардлыг 5.2 сая төгрөгөөр, барилгын хуримтлагдсан элэгдлийг 5.2 сая төгрөгөөр тус тус илүү бүртгэсэн байна.

Гадаад валютаарх ажил гүйлгээний хувьд, УСНББОУС 4(24)-д “Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө тухай ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар гадаад валютын дүнг бүртгэлийн валют руу хөрвүүлэх ёстой”, “НББ-ийн тухай” хуулийн 9.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага гадаад валютаар хийсэн орлого, зарлагыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлж бүртгэнэ”, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тооцож зарлах журам”-ын 1.3-т “Монголбанкнаас зарласан хаалтын ханшийг дараа өдөр нягтлан бодох бүртгэлд хүчинтэй мөрдөнө” гэж тус тус заасныг зөрчсөн, ашиглалтын хугацааг алдаатай тооцсон байдал нь УСНББОУС 1(27)-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Уг алдааг залруулахаар зөвлөмж өгсөн боловч залруулгыг хийлгүүлээгүй. Сургуулийн зүгээс Нягтлан бодох бүртгэлийн програмд энэхүү алдааг залруулах боломжгүй тул залруулах тухай зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүйгээ мэдэгдсэн. УСНББОУС-4 “Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тооцож зарлах журам”, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ыг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Бүртгэлийн програм хангамжийн боломжгүй(уг загварын програм хангамжийн хөгжүүлэлт зогссон) байдлаас шалтгаалан 6.5 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

АШУҮИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2004 онд анх боловсруулагдсан бөгөөд түүнээс хойш өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй, анх боловсруулахдаа учир дутагдалтай (дагаж мөрдөх заавар, журам ороогүй, нарийн төвөгтэй тооцооллын талаарх аргачлал, бүртгэлийн горим тусгагдаагүй, төв болон салбар сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хоорондын бүртгэлийн бодлого, горимыг тусгаагүй) хийгдсэн, сургуулийн өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангах боломжгүй болсон байна.

АШУҮИС-ийн бүртгэлийн программын ашиглалт муу, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахаа байсан, програмын бэлтгэн нийлүүлэгч компаниас програмын саатал болон бусад төрлийн үйлчилгээг авахад хэтэрхий их цаг хугацааг зарцуулах шаардлага гардаг байна. Програм нийлүүлэгч компанид програмтай холбоотой асуудлаар АШУҮИС-ийн зүгээс зөвлөгөө, заавар авах талаар хандахад “танай ашиглаж буй програмын зохион байгуулалт нилээд олон жилийн өмнө боловсруулагдсан хувилбар, танайд үүсээд байгаа асуудлыг шийдэх боломжгүй, иймд сүүлийн үеийн шинэчлэгдсэн програм хангамж худалдан авах хэрэгтэй гэдэг” тайлбарыг өгдөг байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

АШУҮИС болон салбар сургуулиуд 2017 оноос эхлэн үндсэн үйл ажиллагааны орлогоо кредит цагийг суурь болгон тооцоолж байгаа эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй. 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсний дагуу үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээг хийлгүүж, үр дүнг бүртгэлд тусгасан байдлыг анхаарч үзэх.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 122,013.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 121,974.4 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 6.5 сая төгрөгийн зөрчлийг залруулаагүй, 33.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 9 асуудлаар санал зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн дагуухолбогдох арга хэмжээг авч 8 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 1 ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Санал дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

АШУУИС-ИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Санхүүгийн тайлагналын материаллаг байдлын үнэлгээ нь 73.7 сая төгрөгөөр тогтоогдсон бөгөөд 2016 оны санхүүгийн тайландахь залруулаагүй зөрчилнь материаллаг бус дүнтэй тул зөрчилгүй санал дүгнэлтийг өгч байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүүгийн тайлан, илтгэх хуудсыг тус тус хавсаргав.



**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар.....15-16

Асуудал 2

Бараа материалын талаар.....16

Асуудал 3

Хүүгийн орлогын талаар.....17

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 4

Сангийн талаар.....18

Асуудал 5

Үндсэн хөрөнгийн талаар.....19

Асуудал 6

Биет бус хөрөнгийн талаар.....20

Асуудал 7

Буцалтгүй тусламжийн орлогын талаар.....21

Асуудал 8

Мөнгөн хөрөнгийн талаар.....22

Асуудал 9

Өмнөх жилийн аудитын зөвлөмжийн биелэлтийн талаар.....23

Менежментийн захидал

Аудитын ажил гүйцэтгэх гэрээгээр “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийн илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал, дүгнэлт гаргахад зориулагдсан. Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Бидний энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1. Үндсэн үйл ажиллагааны орлого	Тэргүүлэх ач холбогдол №1
